

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ 03 ДУГААР ТОГТООЛООР
БАТЛАГДСАН “ӨВЛИЙН СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР”-ИЙН 2022 ОНЫ БИЕЛЭЛТ**

2022.10.07

Баян-Өндөр сум

д/д	Зорилтын нэр	Арга хэмжээний нэр	Суурь түвшин /2021 он /	Хүрэх түвшин	Хэрэгжилт	Хувь
1	5.1. Өвлийн спорт болон нийтийн биеийн тамирыг нийтэд сурталчлах, чийрэгжүүлэлтийн зөв дадал олгох, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх. /дундаж хувь 86/	5.1.1.Өвлийн спортын секц дугуйлангуудын төрөл, тоог нэмэгдүүлэх;	гүйлтийн цана, дугуйд цана, мөсөн шагай, хоккей гэсэн 4 төрлөөр 280 гаруй тамирчид хичээллэсэн	Спортын төрлийг 1-ээр, тамирчдын тоог 40-өөр нэмэгдүүлэх	Өвлийн спортын секц, дугуйланд хоккейн спортоор 90, гүйлтийн цана, дугуйд цанаар-45, уулын цана-100, сноуборд-30, мөсөн шагай 63, мөсөн сур 43, нийт 6 төрлөөр 370 гаруй тамирчин хичээллэж байна. Өмнөх оноос мөсөн сур, уулын цана, сноуборд спортын төрөл, тамирчдын тоо сүүлийн 2 жилд 180-аар нэмэгдсэн.	100%
2		5.1.2.Үндэсний спортын төрөл болох мөсний шагай, мөсөн сурын спортыг хөгжүүлэх, шинэ залуу тамирчдыг бэлтгэх;	Мөсний шагайн спортын төрлөөр 30 тамирчин хичээллэж 2 удаа тэмцээн зохион байгуулсан.	Спортын төрлийг 1-ээр, тамирчдын тоог 20-оор нэмэгдүүлэх	Мөсний шагай, мөсөн сурын спортын төрлөөр насанд хүрэгчид, залуучуудын ангилалд нийт 100 гаруй тамирчдаас 16-25 насны 25 шинэ залуу тамирчид нэмэгдэн хичээллэж байна.	100%
3		5.1.3.Өвлийн спортын чиглэлээр улсын болон бүсийн чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах, оролцох	Тамирчдын тоо 15, Медалийн тоо 11	Тамирчдын тоо 150, Медалийн тоо 70	-Тайлант онд аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг нээлттэйгээр бүсийн чанартай болгон зохион байгууллаа. Мөн өвлийн спортын биатлон, хоккей, гүйлтийн цана, уулын цанын төрлөөр ази тив, улс, бүсийн аварга шалгаруулах 10 тэмцээнд 162 тамирчин оролцсоноос: -ази тивийн аварга шалгаруулах биатлоны тэмцээнд 2 мөнгө , 1 хүрэл медаль, -хоккейн өсвөр үеийн U-10, U-16 насны улсын аварга шалгаруулах тэмцээнээс тус бүр 1 мөнгө, цомын тэмцээнээс 1 мөнгө, насанд хүрэгчдийн лигийн тэмцээнд 1 мөнгө, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд 1 мөнгөн медаль, -гүйлтийн цанын насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс 3 мөнгө, 7 хүрэл медаль,	100%

					<p>-гүйлтийн цанын өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс 1 алт, 7 мөнгө, 3 хүрэл медаль,</p> <p>-уулын цанын өсвөр үе, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс 4 алт, 6 мөнгө, 9 хүрэл медаль тус тус хүртэж, нийт 151 медаль авсан амжилтыг үзүүлсэн нь өмнөх онынхоос спортын төрлийг 1-ээр нэмэгдүүлж, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон тамирчдын тоог 31-ээр нэмэгдүүлсэн.</p> <p>Оролцсон тэмцээнүүдээс дурьдвал:</p> <p>- Гүйлтийн цанын өсвөр үеийн төвийн бүсийн аварга шалгаруулах тэмцээн Төв аймгийн Борнуур суманд зохион байгуулагдсан. Тэмцээнд Улаанбаатар хот, 6 аймгийн 90 гаруй тамирчид оролцож Орхон аймгаас эрэгтэй, 5 эмэгтэй 6 тамирчин оролцож 2 алт, 8 мөнгө, 2 хүрэл медаль хүртэж, багийн дүнгээр 3 байр эзэлсэн.</p> <p>-Гүйлтийн цанын өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн Улаанбаатар хотод зохион байгуулагдсан. Тэмцээнд Улаанбаатар хотын сонгино хайрхан дүүрэг, 10 аймгийн 116 тамирчин хурд хүчээ авахаалж самбаагаа сорьсоноос Орхон аймгийн тамирчид 5 насны ангилалд 15 тамирчин оролцож, 2 алт, 8 мөнгө, 2 хүрэл нийт багийн дүнгээр 3-р байр эзэлсэн.</p> <p>-Гүйлтийн цанын насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн Өвөрхангай аймгийн Бат-өлзийт суманд зохион байгуулагдсан. Тэмцээнд Улаанбаатар хот, 6 аймгийн тамирчид оролцсоноос Орхон аймгаас 11 өсвөрийн тамирчин оролцсоноос 2 мөнгө, 6 хүрэл медаль хүртсэн.</p> <p>-Уулын цанын улсын аварга шалгаруулах тэмцээнд өсвөрийн 25, насанд хүрэгчдээс 6 тамирчин оролцож 4 алт, 6 мөнгө, 9 хүрэл медаль хүртсэн.</p> <p>- ОХУ-ын Буриад улсад Байгаль нууран дээр Максимиha уулын өвөрт Олон улсын уралдаанд Монгол улсаа нийт 14 тамирчин уралдаж, Орхон аймгаас 7 тамирчин оролцсон.</p> <p>-Хоккейн өсвөр үеийн U-10, U-16 улсын аварга шалгаруулах тэмцээнээс тус бүр 1 мөнгө, цомын тэмцээнээс 1 мөнгө, насанд хүрэгчдийн лигийн тэмцээнд 1 мөнгө, залуучуудын улсын аварга шалгаруулах</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>тэмцээнд 1 мөнгөн медаль тус тус хүртсэн амжилтыг үзүүлсэн.</p> <p>-Мөсний шагайн харваа, мөсний сур харваа, гүйлтийн цана, тэшүүрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг өсвөр, насанд хүрэгчдийн ангиллаар нээлттэйгээр бүсийн чанартай болгон зохион байгуулж, Улаанбаатар хот болон 9 аймгийн 260 гаруй тамирчдыг хамруулсан.</p>	
4		<p>5.1.4.Аймаг, орон нутгаас төрөн гарсан ахмад багш болон шилдэг тамирчдаа алдаршуулах, сургалт зохион явуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах;</p>	<p>-3-аас доошгүй тэмцээн, өдөрлөг зохион байгуулах /Ковид-19 цар тахлаас шалтгаалж зохион байгуулаагүй/</p>	<p>4-өөс доошгүй тэмцээн, өдөрлөг зохион байгуулах /Ковид-19 цар тахлаас шалтгаалж “Эрдэнэт мөнгөн өвөл-2022” аяны нээлтийн үйл ажиллагааг цахимаар, тэмцээн уралдааныг хязгаарлалттай зохион байгуулсан/</p>	<p>Өвлийн спортыг хөгжүүлэх, идэвхи санаачилгатай ажиллаж байгаа спорт холбоод, тамирчдыг алдаршуулах, олон нийтэд сурталчлах зорилгоор “Эрдэнэт мөнгөн өвөл-2022” аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд дараах тэмцээн уралдаан, сургалтын арга хэмжээг зохион байгуулсан.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Аймгийн хүчний байгууллагуудын дунд Биатлоны тэмцээн; -Тэшүүрийн аймгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээн; - Уулын цанын аймгийн аварга шалгаруулах тэмцээн -Гүйлтийн цанын аймгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг тус тус зохион байгуулсан. -Өвлийн спортыг хөгжүүлэх, иргэд олон нийтэд сурталчлах зорилгоор 1 видео үзүүлбэр, 6 постер, 2 шторк бэлтгэж хэвлэл мэдээлэл болон сошиал сүлжээгээр иргэдэд сурталчилсан; - Монголын үндэсний "Цасан зам" спортын холбоо, аймгийн Биеийн тамир, спортын газар хамтран ерөнхий боловсролын сургуулиудын 26 биеийн тамирын багш, дасгалжуулагч нарт "Цанын спортыг хөгжүүлэх арга зүйн" сургалтыг зохион байгуулсан. -Соёл урлагийн байгууллагуудын дунд “Цасны баяр” өдөрлөгийг 9 байгууллагын 72 ажилтныг хамруулан “Олс таталт”, “буухиа тэшүүр”, “мөсний шагай”-н тэмцээнүүдийг тус тус зохион байгуулсан. <p>Тайлант оны 11-12 дугаар сард “Эрдэнэт мөнгөн өвөл-2022” аян үргэлжилнэ.</p>	100%
5		<p>5.1.5.Өвлийн спортын хувцас, хэрэглэл, материал</p>	<p>Спортын төрөлжсөн 1</p>	<p>Аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй</p>	<p>Манай аймагт спортын төрөлжсөн 1 дэлгүүр, спорт хувцасны оёдлын цех 3 тус тус үйл ажиллагаа явуулж байна. Спорт барааны дэлгүүрт худалдаж буй хувцас</p>	30%

		оёдог, зардаг спорт барааны дэлгүүр, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийг дэмжиж, хамтран ажиллах	дэлгүүр, 3 оёдлын цех ажилладаг.	хамтран ажиллах	хэрэглэгдэхүүн нь Улаанбаатар хоттой харьцуулахад үнэ өндөр, оёдлын цехүүдэд өвлийн спортын хувцас оёх зориулалтын машин байхгүй байна.	
6	5.2.Аймгийн өсвөрийн шигшээ багийн тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулах, оролцуулах нөхцөл бололцоогоор хангах /дундаж хувь 92.5/	5.2.1.Жил бүр өвлийн спортын 3-4 төрлөөр аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг тогтмол зохион байгуулж хэвших;	ААШТэмцээн 3 /цана, тэшүүр, мөсөн шагай/	ААШТ 6 удаа /биатлон, гүйлтийн цана,уулын цана, тэшүүр, мөсний шагай, мөсний сур харваа/	Өвлийн спортын мөсний сур харваа, мөсний шагайн харваа, тэшүүр, гүйлтийн цана, уулын цана, биатлоны спортын төрлүүдээр аймгийн аварга шалгаруулах 6 тэмцээнийг зохион байгуулж, 337 тамирчныг хамруулсан.Тухайлбал: -Мөсний сур харвааны аймгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнд Эрдэнэт, Хөвсгөл, Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн 70 гаруй харваач оролцсон. -Мөсний шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнд Улаанбаатар хот, Дархан-Уул, Архангай, Булган, Орхон аймгийн мөсөн шагайн 60 тамирчин талын харваа болон цуваа харвааны төрлөөр хурц мэргэнээ сорин наадаж аваргуудаа тодруулсан. - Уулын цанын аймгийн аварга шалгаруулах тэмцээн нь 4 насны ангилалд зохион байгуулж, 50 гаруй тамирчныг хамруулсан. -Аймгийн хүчний байгууллагын дунд биатлоны насанд хүрэгчдийн тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд Зэвсэгт хүчний 186-р анги, Зэвсэгт хүчний 110-р анги, Онцгой байдлын газрын нийт 24 тамирчныг хамруулсан. -Гүйлтийн цанын аймгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнд Булган, Төв, Дархан –уул, Хэнтий, Орхон аймгуудын өсвөр үеийн 4 насны ангиллаар, насанд хүрэгчдийн 2 насны ангиллаар ойрын зай буюу тэшилтийн төрөл, холын зай буюу сонгомолын төрлөөр зохион байгуулж, нийт 80 гаруй тамирчдыг хамруулсан. -Тэшүүрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 5 насны ангиллаар нээлттэй зохион байгуулж, Булган аймгийн Сэлэнгэ сумын тэшүүрийн тамирчид, Орхон аймгийн ерөнхий боловсролын 9-н сургуулийн 53 тамирчдыг хамруулсан.	100%
7		5.2.2.Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бусад	Хамтарсан бэлтгэлийн тоо-3	Хамтарсан бэлтгэлийн тоо-3	Өвлийн спортын хоккей, гүйлтийн цана, мөсөн шагай, мөсөн сурын төрлүүдээр 86 тамирчин хамтарсан бэлтгэл	100%

		аймаг, сумын баг тамирчидтай хамтарсан туршлага солилцох уулзалт, нөхөрсөг тэмцээн болон сэргэлтийн бэлтгэлийг зохион байгуулах;			сургуулилт хийж, тэмцээн уралдаанд оролцсон. Тухайлбайл: -Хоккейн өсвөрийн U-13, U-15 шигшээ багийн 30 тамирчин ОХУ-н Улаан-үд хотод хамтарсан бэлтгэл сургуулилт хийж, нөхөрсөг тэмцээн зохион байгуулсан. -Дархан-Уул, Хэнтий аймгийн гүйлтийн цанын 10 тамирчин манай аймагт ирж шигшээ багийн 16 тамирчинтай хамтарсан бэлтгэл хийсэн. -Мөсөн шагайн харваа, мөсөн сурын харвааны төрлөөр Улаанбаатар хот, Дархан-Уул, Архангай, Булган, Хөвсгөл, Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн 40 гаруй тамирчид манай аймагт ирж хамтарсан бэлтгэл хийж тэмцээнд оролцсон. -Гүйлтийн цанын 11 тамирчин Хүүхэд, гэр бүл залуучуудын хөгжлийн газрын харьяа “Янзага зусланд 10 хоног сэргэлтийн бэлтгэлд хамрагдсан.	
8		5.2.3.Тамирчдын залгамж халааг бэлтгэх зорилгоор төрөлжсөн сургалттай спортын дунд сургуульд жил бүр цана, тэшүүрийн тамирчдын элсэлт авах	Цана-6 Тэшүүр-0	Цана-8 Тэшүүр-0	2022-2023 оны хичээлийн жилийн 2-р улиралд спортын төрөлжсөн сургалттай “Ирээдүйн одод” сургуульд цанын спортын мэргэжлийн багш, “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-н мөсөн талбайд тэшүүрийн спортын мастер секц ажиллуулна. “Ирээдүйн хос мөртөн” цанын клубт өсвөрийн 20 хүүхэд хичээллэж байна.	70%
9		5.2.4.Дэлхий, тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт гаргасан тамирчдыг жил бүр урамшуулах;	-	амжилт гаргасан тамирчдыг урамшуулах	Тайлант онд тив, улсын аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт гаргасан тамирчдыг аймгийн Засаг даргын 2015 оны А/445 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу урамшууллыг 2023 онд олгохоор төлөвлөсөн.Урамшуулалд ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд 2, улсын аварга шалгаруулах тэмцээнд 149 тамирчин нийт 151 тамирчин /багийн болон ганцаарчилсан төрлөөр/ хамруулахаар судалгаа гаргасан.	100%
10	5.3.Орон нутагт өвлийн спортын мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор	5.3.1.Ерөнхий боловсролын сургуулиудад биеийн тамирын	Зохион байгуулах сургалт-2	Зохион байгуулах сургалт-3	-Аймгийн засаг даргын 2022 оны А/47 дугаар захирамжаар батлагдсан “Эрдэнэт мөнгөн өвөл-2022” аяны хүрээнд Монголын үндэсний "Цасан зам" спортын холбоо, аймгийн Биеийн тамир, спортын газар хамтран	100%

	суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах.	багшийг өвлийн спортын төрөл хариуцуулж ажиллуулах, богино хугацааны сургалтаар мэргэшүүлж, чадваржуулах;			ерөнхий боловсролын сургуулиудын 26 биеийн тамирын багш, дасгалжуулагч нарт "Цанын спортыг хөгжүүлэх арга зүйн " онол практик хосолсон сургалтыг танхимаар 3 удаа зохион байгуулсан.	
11	/дундаж хувь 100/	5.3.2.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, спортын клуб, холбоодтой хамтран ажиллах;	Спорт холбоо-3 /Цанын холбоо-2, мөсөн шагайн холбоо-1/, Хичээллэгчид 1400 хүн	Спорт холбоо-4, Хичээллэгчид 1800 хүн	-Өвлийн спортын "Хоккейн", "Мөсөн сур", "Мөсөн шагай"спорт холбоод, "Ирээдүйн хос мөртөн" цанын клубтэй хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллаж байна. Мөн Монголын үндэсний "Цасан зам" цанын холбоо, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-н Спорт цогцолбор, аймгийн Онцгой байдлын газар, Соёл урлагийн газартай хамтран ажиллаж байна. -"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-н Сархиа цанын бааз, "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-н тэшүүрийн талбай, Орос 16 дугаар сургуулийн хоккейн талбайд давхардсан тоогоор 3200 гаруй иргэн чарга, уулын цана, тэшүүр, хоккейн спортоор хичээллэсэн.	100%
12		5.3.3.Өвлийн спортыг хөгжүүлэх чиглэлээр идэвх санаачилгатай, амжилттай ажиллаж байгаа багш дасгалжуулагч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх;	2020-2021 онд өвлийн спортын 8 төрлөөр 33 тамирчинд 8,9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	Спорт холбоодод дэмжлэг үзүүлэх	-Аймгийн засаг даргын 2022 оны А/47 дугаар захирамжаар батлагдсан "Эрдэнэт мөнгөн өвөл-2022" аяны хүрээнд өвлийн спортын шилдэг 5 холбоо,1 дасгалжуулагч багш, 5 тамирчинг шагнаж урамшуулсан. -Өвлийн спортыг хөгжүүлэх чиглэлээр идэвх санаачилгатай, амжилттай ажиллаж байгаа "Мөсөн шагайн холбоо"-нд 1.7, "Мөсөн сурын холбоо" 3.5, "Ирээдүйн хос мөртөн цанын клуб"-т 12.1 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн.	100%
13		5.4.1.Тамирчид, хүүхэд багачууд, иргэдийн бэлтгэл сургуулилт хийх чөлөөт цагаа өнгөрүүлэх цанын	Талбайн тоо-4	Талбайн тоо-5	-Тайлант онд "Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ" Сархиа цанын бааз, мөсөн гулгуурын талбай, Орос 16-р сургуулийн хоккейн талбайд өөрийн хөрөнгөөр цас, мөс тавьсан. - Онцгой байдлын газартай хамтран "Эрдэнэт спорт амралтын хүрээлэн"-д 400 метрийн мөс тавьж, 1 иргэнтэй гэрээ хийж 01-03 дугаар сар хүртэл тэшүүрийн түрээсийн	90%

	5.4.Өвлийн спортын төрлөөр хичээллэх орчинг бүрдүүлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх.	зам, тэшүүр, хоккейн талбайд мөс тавих;			үйлчилгээ үзүүлсэн. Энэ хугацаанд түрээсийн үйлчилгээнд давхардсан тоогоор нийт 1200 гаруй хүн хамрагдсан. -Монголын үндэсний “Цасан зам” цанын холбоотой хамтран Сархиа уулын энгэрт гүйлтийн цанын 2.5 км замын трансиг тогтоолгож ажиллалаа. -Ерөнхий боловсролын сургуулиудын гадна талбайд мөс тавихаар аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран ажиллаж байна.	
14	/дундаж 67.5 хувь/	5.4.2.Спорт амралтын хүрээлэнгийн төв асар болон Орос сургуулийн гаднах хоккейн талбайд тамирчдын хувцас солих дулаан өрөө, танхимыг тохижуулах;	-	-	-Тайлант онд Хангарьд спорт цогцолбор өөрийн хөрөнгөөр Орос 16-р сургуулийн хоккейн талбай хувцас солих өрөөг тохижуулсан. Эрдэнэт спорт, амралтын хүрээлэнгийн төв асарт тэшүүрийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх иргэнтэй гэрээ байгуулж, цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэсэн.	50%
15		5.4.3.Тамирчдын бэлтгэл сургуулилт болон хичээлийн хөтөлбөрт ашиглах цана, тэшүүр, хэрэглэл материалаар хангах;	Цана-11 Тэшүүр-6	Цана-17 Тэшүүр-10	Тайлан онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар уралдааны болон бэлтгэлийн 12 ширхэг цана, 8 ширхэг тэшүүрийг нийт 33.3 сая төгрөгийн үнэ бүхий хэрэгсэл материалыг хүлээн авч, тамирчдын бэлтгэл сургуулилтыг хийлгэлээ.	100%
16		5.4.4.Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын Хангарьд спорт цогцолборын дэргэдэх хоккейн талбайд битүү дээвэртэй мөсөн талбай бүхий ордон байгуулах;	-	-	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н Спорт цогцолборт албан бичиг хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй.	30%

“ӨВЛИЙН СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

2022.09.28

№	Үндсэн зорилтууд	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		
			2019 он	2021 он	2022 он	2023 он
1	Орон нутагт өвлийн спортын мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын спорт хариуцсан арга зүйч болон ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багшийг өвлийн спортын төрөл хариуцуулж ажиллуулах, богино хугацааны сургалтаар мэргэшүүлж, чадавхижуулах	Зохион байгуулах сургалт-1	Зохион байгуулах сургалт-2	Зохион байгуулах сургалт-3	Зохион байгуулах сургалт-5
2	Өвлийн спортын төрлөөр хичээллэх орчинг бүрдүүлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх.	Тамирчид, хүүхэд багачууд, иргэдийн бэлтгэл сургуулилт хийх чөлөөт цагаа өнгөрүүлэх цанын зам, тэшүүр, хоккейн талбай тавих	4	4	5	6
		Спорт амралтын хүрээлэнгийн төв асар болон Орос сургуулийн гаднах Хоккейн талбайд тамирчдын хувцас солих дулаан өрөө, танхимыг тохижуулах	-	-	1	1
		Тамирчдын бэлтгэл сургуулилт болон хичээлийн хөтөлбөрт ашиглах цана, тэшүүр, хэрэглэл материалаар хангах	Цана-0 Тэшүүр-0	Цана-6 Тэшүүр-6	Цана-12 Тэшүүр-8	Цана-90 Тэшүүр-86
		Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Хангарьд спорт цогцолборын дэргэдэх хоккейн талбайд битүү	-	-	-	1

		дээвэртэй мөсөн талбай бүхий ордон байгуулах				
3	Өвлийн спорт болон нийтийн биеийн тамирыг нийтэд сурталчлах, чийрэгжүүлэлтийн зөв дадал олгох, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх.	Өвлийн спортын төрлийн спорт холбоод, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх	Спорт холбоод 2, Хичээллэгчид 1400	Спорт холбоо-3 /Цанын холбоо-2, мөсөн шагайн холбоо-1/ Хичээллэгчид 1600 хүн	Спорт холбоо-4, Хичээллэгчид 1800 хүн	Спорт холбоод 4, Хичээллэгчид 20% -иар нэмэгдүүлэх
		Улсын чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах	2	-	-	4
		Тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээн болон нэрэмжит тэмцээнд оролцсон тамирчдын тоо, амжилт нэмэгдсэн байна.	Тамирчдын тоо 195, Медалийн тоо 69	Тамирчдын тоо 15, Медалийн тоо 11	Тамирчдын тоо 150, Медалийн тоо 70	Тамирчдын тоо 210 Медалийн тоо 80
4	Аймгийн өсвөрийн шигшээ багийн тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулах, оролцуулах нөхцөл бололцоогоор хангах	Өвлийн спортын төрлүүдээр аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг тогтмол зохион байгуулах, спортын холбоо, клубтэй хамтран ажиллах	ААШТэмцээн 3 удаа /гүйлтийн цана, хоккей, мөсөн шагай/	ААШТэмцээн 3 /гүйлтийн цана, тэшүүр, мөсөн шагай/	ААШТ 6 удаа /биатлон, гүйлтийн цана, уулын цана, тэшүүр, мөсний шагай, мөсний сур харваа/	ААШТ 8 удаа /биатлон, гүйлтийн цана, тэшүүр, шорт трек, хоккей, мөсний шагай, мөсний сур харваа/

		Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бусад аймаг, сумын баг тамирчидтай хамтарсан бэлтгэлд гаргах, туршлага солилцох уулзалт, нөхөрсөг тэмцээн зохион байгуулах, оролцох	4	3	3	6
		Тамирчдын залгамж халааг бэлтгэх зорилгоор төрөлжсөн сургалттай спортын дунд сургуульд жил бүр цана, тэшүүрийн тамирчдын элсэлт авна.	Цана-15 Тэшүүр-0	Цана-6 Тэшүүр-0	Цана-8 Тэшүүр-0	Цана-30 Тэшүүр-15